

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны
... дугаар сарын ... - ны өдрийн ... дугаар
тушаалын хавсралт

Төмөр замын тээвэр дэх осол, гологдлыг Судлан бүртгэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар суурь бүтэц, тээвэрлэгч, төмөр замын тээвэрт оролцогчдын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд гарсан хөдөлгөөний аюулгүй байдалд гарсан сүйрэл, осол, гологдлыг шалган тогтоож судлан шинжлэх, бүртгэх, мэдээлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Үйлдвэрлэлийн ослыг шинжлэн судлахтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулахгүй.

1.3. Сүйрэл, осол, гологдлыг эрүүгийн болон хөдөлмөрийн харилцаатай холбогдуулан шалгаж байгаа эсэхээс үл хамааран шалтгааныг нь судлах, мэргэжлийн дүгнэлт гаргах, арга хэмжээ тооцох, бүртгэх байнгын болон байнгын бус ажлын хэсэг томилох, ажиллуулахыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

Хоёр. Сүйрэл, осол, гологдлын ангилал

2.1. Зорчигчийн болон ачааны галт тэрэг нь өөр галт тэрэг, хөдлөх бүрэлдэхүүнтэй мөргөлдсөн болон хөдлөх бүрэлдэхүүн замаас гарсны улмаас хүний амь нас хохирсон, хөдлөх бүрэлдэхүүн эвдэрч дахин ашиглах боломжгүй болсон нөхцөл байдал үүссэнийг сүйрэл гэнэ.

2.2. Осол гэж дараах нөхцөл байдал үүссэнийг тооцно:

2.2.1. зорчигчийн галт тэрэг өөр галт тэрэг, хөдлөх бүрэлдэхүүнтэй мөргөлдсөн;

2.2.2. зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүн замаас гарсан;

2.2.3. ачааны галт тэрэг өөр ачааны галт тэрэг, хөдлөх бүрэлдэхүүнтэй мөргөлдсөн буюу хөдлөх бүрэлдэхүүн замаас гарсны улмаас энэхүү журмын 2.1.1-д заасан хор хохирол учраагүй бөгөөд хөдлөх бүрэлдэхүүн их засварт орохоор эвдэрсэн;

2.2.4. сэлгээ, зэхэлтийн болон бусад хөдөлгөөний үед хөдлөх бүрэлдэхүүн мөргөлдсөн буюу замаас гарсны улмаас хүний амь нас хохирсон, хүнд гэмтэл учирсан, хөдлөх бүрэлдэхүүн их засварт орохоор эвдэрсэн;

2.2.5. аюултай ачаа тээвэрлэх явцад хөдлөх бүрэлдэхүүн болон бусад шалтгааны гэмтлийн улмаас аюултай ачаа асгарч хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, бусдын өмч хөрөнгөд их хэмжээний хохирол учирсан.

2.3. Гологдол гэж дараах нөхцөл байдал үүссэнийг тооцно:

2.3.1. хөдлөх бүрэлдэхүүн мөргөлдсөн – Хоорондын замд болон өртөө, зөрлөгт галт тэрэг өөр галт тэрэгтэй буюу хөдлөх бүрэлдэхүүнтэй мөргөлдсөн, сэлгээ, зэхэлт, бусад хөдөлгөөний үед хөдлөх бүрэлдэхүүн өөр хоорондоо мөргөлдсөн, эсвэл хязгаарын шонгийн гадна нэг хөдлөх бүрэлдэхүүн нөгөөгийн хажуугаас мөргөснөөс болж энэ журмын 2.1, 2.2-т заасан хохирол учраагүй боловч хөдлөх бүрэлдэхүүнийг засварлахаар гэмтсэн бүх тохиолдол;

2.3.2. хөдлөх бүрэлдэхүүн замаас гарсан – Галт тэрэгний бүрэлдэхүүнээс хоорондын зам, өртөө, зөрлөгийн замд мөн түүнчлэн салбар замд сэлгээ, зэхэлт, бусад хөдөлгөөний үед хөдлөх бүрэлдэхүүний хос дугуй зам төмрийн толгойноос унаж замаас гарсанаас энэ журмын 2.1, 2.2-т заасан хохирол учраагүй бүх тохиолдол;

2.3.3. эзэлгээтэй замаар галт тэрэг хүлээн авсан – Нээлттэй оруулах буюу урих дохиогоор эсвэл өртөөний эзэлгээтэй зам руу орох зөвшөөрөл авсан галт тэрэг оруулах дохио өнгөрсөн;

2.3.4. эзэлгээтэй хоорондын замд галт тэрэг явуулсан – Хагас автомат хориглолын үед галт тэрэг буюу хөдлөх бүрэлдэхүүнээр эзлэгдсэн хоорондын зам руу гаргах дохио нээж эсвэл хоорондын зам эзлэх зөвшөөрөл машинчид гардуулж явуулснаас уул хоорондын замын гаргах дохио /гаргах дохиогүй бол хязгаарын шон/-г хөдлөх бүрэлдэхүүний аль нэг хэсгээр өнгөрсөн тохиолдол;

2.3.5. бэлэн бус замналаар галт тэрэг хүлээн авсан – Өртөөнд ирж байгаа галт тэргийг хүлээн авахдаа ямар ч зам дээр замнал бэлтгээгүй байж оруулах дохионы хориглосон заалтыг өнгөрөх эрх олгож оруулсан бүх тохиолдол;

2.3.6. бэлэн бус замналаар галт тэрэг явуулсан – Өртөөнөөс зэргэлдээ өртөө рүү галт тэрэг явуулахаар замналыг бэлтгэхдээ явах галт тэрэгний зам дээр замналаа бэлтгээгүй байж, уг галт тэргэнд хоорондын зам эзлэх эрх олгож явах тушаал өгөх, явуулах зэрэг тохиолдол;

2.3.7. хориглосон дохио өнгөрсөн – Галт тэрэг буюу ганцаар яваа зүтгүүр, замаас авагддаггүй нэгжүүдийг өртөөнд хүлээн авах, явуулах болон сэлгээний үед хориглосон заалттай дохиог /зөөврийн зогсох дохио бүрийг/, дохиогүй өртөөдөд хязгаарын шонг өнгөрсөн тохиолдол;

2.3.8. хөдлөх бүрэлдэхүүн дор сум эргэсэн – Цахилгаан төвлөрүүлэлтийн төхөөрөмж гэмтсэнээс буюу сумын секц хөдлөх бүрэлдэхүүнээс бүрэн чөлөөлөгдсөнийг магадлалгүйгээр албадан гуйвуулсан буруу үйл ажиллагааны улмаас, эсвэл зам төмрийн хэлхээний мэдрэмж алдагдсанаас /зэвэрсэн, элс, шороо, тосонд дарагдсан г.м/ сум хөдлөх бүрэлдэхүүн дор эргэж тухайн замналаас өөр замнал бэлтгэгдсэн тохиолдол;

2.3.9. хөдлөх бүрэлдэхүүн өөрөө хөдөлсөн – Өртөөний болон салаа салбар замд хөдлөх бүрэлдэхүүн өөрөө хөдөлсөн;

2.3.10. хөдлөх бүрэлдэхүүний эд анги хугарсан – Хөдлөх бүрэлдэхүүний хос дугуйн гол, голын хүзүү буюу дугуй, хажуу арал, нумын дээд дам нуруу, ноён нуруу хугарсан, тасарсан, хагарсан тохиолдол;

2.3.11. зорчигчийн вагон салгасан – Аялалын замд зорчигчийн галт тэрэгнээс явуулах болон хүрэх өртөөнөөс бусад бүх өртөөд дээр, галт тэрэгний цаашдын хөдөлгөөнд саад болох гэмтлийн улмаас вагон салгасан тохиолдол;

2.3.12. галт тэргэнд эд юмс дайрагдсан – Галт тэрэг болон сэлгээний бүрэлдэхүүнд тээврийн хэрэгсэл, хөдлөх бүрэлдэхүүний эд анги, тоормосын ивүүр, замаас авагддаг нэгжүүд, замын дээд цогцын материал /чигжээсээс бусад/ замын багажууд, ачаа бараа дайрагдсан, шүргэгдсэн бүх тохиолдол. Ивүүртэй явуулсан тохиолдол энэ ангилалд орно;

2.3.13. тээврийн хэрэгсэл дайрагдсан – Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн тээврийн хэрэгсэлтэй мөргөлдсөн, сүйрэл, ослын хэмжээний үр дагавар гараагүй тохиолдол;

2.3.14. ДТХ, эрчим хүч тасалдсан – ДТХ-ын төхөөрөмж, зам төмрийн хэлхээ, эрчим хүч шугамын гэмтлээс өртөө хоорондын хориглол, хагас автомат хориглол 4 ба түүнээс дээш цагаар хаагдсан. Мөн эрчим хүч тасарсан үед нөөцийн цахилгаан станц ажиллахгүйгээс хагас автомат хориглол 2 ба түүнээс дээш цагаар хаагдсан тохиолдол;

2.3.15. төгсгөлийн кран хаалттай явуулсан – Галт тэрэгний хөдлөх бүрэлдэхүүн хооронд төгсгөлийн кран хаалттай явуулсан тохиолдол;

2.3.16. зорчигчийн галт тэрэгний зүтгүүр эвдэрсэн – Зорчигчийн галт тэрэгний зүтгүүр техникийн гэмтэл гарч хоорондын зам буюу завсрын өртөөнд тусламж авсан, зүтгүүр сольсон тохиолдол;

2.3.17. хөдлөх бүрэлдэхүүний эд анги зам дээр унасан – Хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөний явцад түүний эд анги зам дээр (зам төмрийн цариг дотор, замын хажуу захад) унасны улмаас цаашид хөдөлгөөн үргэлжлүүлэх боломжгүй болсон, төмөр замын бусад тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан тохиолдол;

2.3.18. аялалын үед зам дээр ачаа унасан – Шингэн болон нурмаг ачаанаас бусад ачаа (чингэлэг) эсвэл тэдгээрийн аль нэг хэсэг зам дээр унах, бэхэлгээ тасарч ачаа байрнаас хөдөлж тогтоосон ачилтын овороос хэтэрсэн тохиолдол.

2.3.19. дохио буруу дохиолсон – Гэрлэн дохионы хориглосон заалт нь зөвшөөрсөн заалт руу эсвэл хурд бууруулахыг шаардсан заалт нь илүү зөвшөөрсөн заалт руу хуурамчаар шилжсэн тохиолдол;

2.3.20. галт тэрэгний авто угсраа тасарсан, салсан – Галт тэрэгний авто угсраа тасарсан болон салсан бүх тохиолдол;

2.3.21. сум зүссэн – Өртөө, зөрлөг, салаа, салбар зам дээр сум зүсэгдсэн бүх тохиолдол;

2.3.22. вагон салгасан – Гүүшин халсны улмаас техник үзлэгийн нэгж бүхий өртөөд болон баталгаат мөрийн төгсгөлийн өртөөнөөс бусад бүх өртөөн дээр ачааны галт тэрэгнээс вагон салгасан тохиолдол;

2.3.23. ачааны нөхцлөөс хамаарч вагон салгасан – Ачаа, тээш, ачаан тээшийн ачилтын техникийн нөхцөлүүдийг зөрчсөний улмаас ачаа юм уу ачааны зарим хэсэг зам дээр унаж болзошгүй, мөн түүнчилэн ачаа ачилтын овороос хэтэрсний улмаас хэсгийн өртөөнөөс бусад бүх өртөөд дээр галт тэрэгнээс вагоныг салгасан тохиолдол;

2.3.24. хос дугуй гацсан – Гүүшин буюу татах цахилгаан хөдөлгүүр гацсан, хос дугуйн гадаргууд зөвшөөрөгдөх хэмжээнээс их чирэг, шаваас гарсан бүх тохиолдол;

2.3.25. зам төмөр ухсан – Зүтгүүрийн болон бусад өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүний хос дугуйгаар зам төмрийг зөвшөөрөгдсөн хэмжээнээс ихээр ухаж солих хэмжээнд хүргэсэн тохиолдол;

2.3.26. зам төмөр хугарсан – Өртөө зөрлөг, хоорондын замд энэхүү журмын 2.3.25-т зааснаас бусад шалтгаанаар зам төмөр хугарсан бүх тохиолдол;

2.3.27. галт тэргэнд мал дайрагдсан – Өртөө, зөрлөг, гарам, хоорондын болон салаа, салбар замд бод мал, биеэр том ан амьтан галт тэргэнд, сэлгээнд дайрагдсан бүх тохиолдол. Дээрх тохиолдолд малын эзэн нь төмөр замын ажилтан бол, түүний харъяа алба, аж ахуйн нэгжид, хэрэв малын эзэн тогтоогдохгүй бол замын ангид тооцно. Хамгаалалттай парк, гарам, гүүрийн хязгаарт бол малын эзэн хэн байхаас хамаарахгүйгээр түүний харъяалдаг алба, аж ахуйн нэгжид тооцно;

2.3.28. усанд автах, элс, цасанд дарагдах, гал түймэрт өртөх – Суурь бүтцийн бүрэн бүтэн байдал алдагдсан, газрын доорхи усны болон урсгал усны түвшин нэмэгдсэнээс суурь бүтэц усанд автсан, материалын болон хүний амь нас, эрүүл мэндэд нь хохирол учруулсан хяналтгүй гал түймэр зэргээс болж галт тэрэгний хөдөлгөөнийг нэг цагаас дээш хугацаагаар бүрэн зогсоосон тохиолдол;

2.3.29. зорчигчийн галт тэрэг цуцалсан, зорчигч буулгасан – Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний техникийн гэмтлээс шалтгаалж галт тэрэг явуулах өртөөнөөс зорчигчийн галт тэрэгний явуулалтыг цуцалсан буюу завсрын өртөөнд зорчигчдийг буулгасан тохиолдол;

2.3.30. вагон, чингэлэг дэх ачаа шатах – Хоорондын зам, өртөө, зөрлөг, салбар замд вагон, чингэлэгт ачсан ачаа шатсан бүх тохиолдол.

Гурав. Сүйрэл, осол, гологдлыг мэдээлэх

3.1. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь дараах нөхцөл байдал бий болсныг мэдсэн даруйд төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шуурхай мэдээлнэ:

3.1.1. энэ журмын 2.1, 2.2, 2.3.1-д заасан нөхцөл байдал бий болсон;

3.1.2. энэ журмын 2.3.2-т заасан нөхцөл байдлын улмаас бусдын амь нас үрэгдсэн буюу нэг буюу түүнээс дээш хүн хүндээр гэмтсэн;

3.1.3. энэ журмын 2.3.2-т заасан нөхцөл байдал тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нэг буюу түүнээс дээш этгээдийг хамарсан;

3.1.4. галт тэргэнд хүн дайрагдсан.

3.2. Шуурхай мэдээлэл нь ямар үйл явдал болсон, тухайн сүйрэл, осол, гологдол болсон газар, огноо, цаг, үүссэн хохирлын шинж чанар, хэр хэмжээ, холбогдох тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн нэр, холбогдох утас, цахим хаяг зэргийг багтаасан байна.

3.3. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь энэ журмын 3.1-д заасан мэдээллийг баталгаажуулж тухайн нөхцөл байдал бий болсноос хойш ажлын 12 цагийн дотор баталсан загварын дагуу бичмэл мэдээллийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.4. Сүйрэл, осол, гологдол гарсан тохиолдолд тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч дараах үүрэг хүлээнэ:

3.4.1. хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалж анхан шатны тусламж үзүүлэх;

3.4.2. хамгийн ойр орших эмнэлгийн байгууллага, суурь бүтэц эзэмшигч болон галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвд мэдэгдэх;

3.4.3. сүйрэл, осол, гологдлын шалтгаан, нөхцөлийг тогтооход ашиглагдаж болох бичиг баримт, замын байгууламжийн болон хөдлөх бүрэлдэхүүний эд анги, бүрдэл хэсэг, эд зүйлийг хэвээр нь хадгалж, хамгаалах, баримтжуулах;

3.4.4. хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, сүйрэл, осол, гологдлоос урьдчилан сэргийлэхэд зайлшгүй шаардлагатай бол сүйрэл, осол, гологдлын улмаас эвдэрч гэмтсэн хөдлөх бүрэлдэхүүн, барилга, байгууламж, эд зүйлсийг эвдэх, задлах, нээх, замаас зайлуулах шуурхай арга хэмжээ авах;

3.4.5. хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бусад шуурхай арга хэмжээ авах.

3.5. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь гарсан сүйрэл, осол, гологдлын шалтгаан, үр дагаварыг арилгах, энэ журмын 3.4-т заасныг зөрчихгүйгээр хөдөлгөөнийг сэргээх арга хэмжээг авч эхлүүлнэ.

3.6. Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчоос бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллага сүйрэл, осол, гологдол болсон тухай холбогдох байгууллагуудад мэдээлэл ирүүлбэл тэдгээр мэдээллийн үнэн, бодитой эсэхийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нар нягтлан шалгасны үндсэн дээр шинжлэн судална.

Дөрөв. Сүйрэл, осол, гологдлыг шинжлэн судлах, бүртгэх

4.1. Шинжлэн судлах, бүртгэх үйл ажиллагаа нь мэдээлэл цуглуулах, холбогдох баримт бичиг бүрдүүлэх, шалган турших, дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, мэдээлэх, архивлах гэсэн ерөнхий дарааллаар явагдана.

4.2. Шинжлэн судлах, бүртгэх ажиллагаа нь сүйрэл, осол, гологдол, зөрчил гарсан шалтгаан, нөхцөлийг үнэн, зөв тогтоох, цаашид давтан гарахаас урьдчилан сэргийлэх зорилготой байна.

4.3. Энэ журмын 2.1, 2.2-т заасан нөхцөл байдал бий болсон, 2.3-т заасан нөхцөл байдалд тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч хэд хэдэн этгээд холбогдсон буюу хүний амь үрэгдсэн, нэг буюу түүнээс дээш хүн хүндээр гэмтсэн, олон хүн гэмтсэн бол төмөр замын тээврийн хяналтын улсын ахлах байцаагчийн шийдвэрээр байгуулсан ажлын хэсэг шинжлэн судална. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагч, харьяалах суурь бүтэц эзэмшигч, холбогдох бусад тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагын төлөөлөл орно. Тус ажлын хэсгийн ахлагч нь төмөр замын тээврийн хяналтын улсын ахлах байцаагч, эсвэл түүний томилсон төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагч байна.

4.4. Энэ журмын 4.3-т зааснаас бусад гологдлыг тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагын томилсон ажлын хэсэг шинжлэн судална.

4.5. Шаардлагатай бол төмөр замын тээврийн хяналтын улсын ахлах байцаагчийн шийдвэрээр энэ журмын 3.1.1, 3.1.2, 3.1.3-т зааснаас бусад гологдлыг төмөр замын тээврийн хяналтын Улсын байцаагчаар ахлуулсан ажлын хэсэг шинжлэн судалж болно.

4.6. Сүйрэл, осол, гологдол гарсан үед тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь комисс томилогдон ажиллаж эхлэх хүртэл, эсхүл ажлын хэсгийн ахлагчийн даалгаснаар сүйрэл, осол, гологдлын шинж чанараас хамааран дараах ажил үүргийг гүйцэтгэнэ:

4.6.1. Хурд хэмжигчийн тууз, галт тэрэгний хөдөлгөөний мэдээллийг бүртгэх төхөөрөмж /мэдээлэл хадгалагч/, галт тэрэгний биечилсэн хуудас, тормозны хангамжийн мэдээлэл, хурд хязгаарласан тухай анхаарамж, зүтгүүрийн ширээний журнал, бусад бичиг баримтыг шалгаж, шаардлагатай бол эхээр нь буюу хуулбарлан авна.

4.6.2. Сүйрэл, осол, гологдол гарсан газар, хөдлөх бүрэлдэхүүн, суурь бүтцийн техникийн байдалд үзлэг хийсэн тухай акт үйлдэнэ.

4.6.3. Хөдлөх бүрэлдэхүүн болон суурь бүтэц, замын байгууламжийн гэмтлийг тодорхойлно.

4.6.4. Сүйрэл, осол, гологдлын нөхцөл байдал, төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний байдал, эвдрэл гэмтэл, гадны болон ойр орчимд байгаа эд зүйлс зэргийг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулна.

4.6.5. Сүйрэл, осол, гологдолд холбоотой ажилтан, гэрчийн этгээдээс бичгээр тодорхойлолт авч, шаардлагатай бол дуу болон дүрс бичлэг хийнэ.

4.6.6. Сүйрэл, осол, гологдол болсныг баталгаажуулах зорилгоор авсан гэрэл зураг, дуу, дүрс бичлэг, ослын дараах хөдлөх бүрэлдэхүүн, суурь бүтцийн тоног, төхөөрөмжийн гэмтэл, арчлалтын норм хэмжээний өөрчлөлт, хөдлөх бүрэлдэхүүний байршил ба замаас гарсан эхлэл төгсгөлийн ул мөр зэргийг заасан бүдүүвч зураг гаргана.

4.6.7. Сүйрэл, осол, гологдол гарах үед цаг агаарын байдал ямар байсан тухай тэмдэглэл хийж, шаардлагатай бол холбогдох баримтыг авна.

4.7. Ажлын хэсэг шинжлэн судлах ажиллагааг хийж, дүгнэлтийг ажлын 5 хоногт багтаан гаргана. Нэмэлт баримт, мэдээлэл, шалган турших ажиллагаа шаардлагатай бол тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн шинжлэн судлах хугацааг салбар, чиглэл хариуцсан улсын байцаагчийн шийдвэрээр, улсын байцаагчийн шинжлэн судлах хугацааг улсын ахлах байцаагчийн шийдвэрээр сунгаж болно.

4.8. Дүгнэлтийг хамтын шийдвэрээр гаргаж ажлын хэсгийн бүх гишүүд гарын үсэг зурах ба дүгнэлттэй санал нийлэхгүй гишүүн тэр тухайгаа тэмдэглэн гарын үсэг зурж хавсаргана.

4.9. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн томилсон ажлын хэсгийн дүгнэлт зохих ёсоор хийгдэж, шаардлага хангасан эсэхийг улсын байцаагч, улсын байцаагчийн ахалсан ажлын хэсгийн дүгнэлтийг улсын ахлах байцаагч тус тус хянаж, шаардлагатай гэж үзвэл дүгнэлтийг хүчингүй болгож, дахин дүн шинжилгээ хийлгэх арга хэмжээ авна.

4.10. Дахин хийгдэх дүн шинжилгээнд тухайн дүн шинжилгээг анх хийсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс оролцуулахыг хориглоно.

Тав. Төмөр замын тээвэрт гарсан сүйрэл, осол, гологдлын дүгнэлтэд хавсаргах баримт, мэдээлэл

5.1. Ажлын хэсгийн дүгнэлтэд энэ журмын 4.6-д заасан ажиллагааг хийж цуглуулсан мэдээллээс гадна дараах баримт, мэдээллийг хавсаргасан байна:

5.1.1. гэмтсэн, хохирсон, хүмүүсийн нэрсийн жагсаалт, гэмтлийн байдлын талаарх эмнэлгийн урьдчилсан дүгнэлт;

5.1.2. хохирлын хэмжээг тодорхойлсон баримт;

5.1.3. шаардлагатай тохиолдолд хийгдсэн шалган турших ажиллагааны акт, дүгнэлт;

5.1.4. галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэсэн зурмагийн хуулбар;

5.1.5. суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтын үеийн техникийн бичиг баримт, бүртгэл, тайлангийн хуулбар (сүйрэл, осол, гологдлын шалтгааныг тогтооход шаардлагатай бол);

5.1.6. сүйрэл, осол, гологдол болсныг баталгаажуулах зорилгоор авсан гэрэл зураг, дуу, дүрс бичлэг, ослын дараах хөдлөх бүрэлдэхүүн, суурь бүтцийн тоног төхөөрөмжийн гэмтэл, арчлалтын норм хэмжээний өөрчлөлт зэргийг заасан бүдүүвч зураг;

5.1.7. тухайн үеийн цаг уурын байдлын талаарх лавлагаа;

5.1.8. техникийн мэдлэгийн шалгалтын баримт, ажлын байрны тодоройлолт, дадлага туршлагын байдал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамрагдсан эсэх, эмнэлгийн үзлэгт орсон тухай магадлагаа, ажил, амралтын дэглэмийн тухай мэдээлэл;

5.1.9. шаардлагатай бусад баримт.

Зургаа. Сүйрэл, осол, гологдлыг бүртгэх, мэдээ гаргах

6.1. Төрийн захиргааны төв байгууллага нь сүйрэл, осол, гологдлын нэгдсэн бүртгэлийг хөтөлж, холбогдох мэдээ, баримтыг хадгална.

6.2. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь онцгой тооцоот гологдол, гологдол, болон төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагааны явцад бусдын амь үрэгдсэн, эрүүл мэндэд хүнд гэмтэл учирсан нөхцөл байдлыг бүртгэн мэдээ, баримтыг хадгална. Харин сүйрэл, ослын зөвхөн бүртгэлийг хөтөлнө.

6.3. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь энэ журмын 6.2-т заасан нөхцөл байдлын тухай мэдээг Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан загварын дагуу сар (дараа сарын 10-ны дотор), улирал (дараа улирлын эхний сарын 10-ны дотор), жил (дараа жилийн 02 дугаар сарын 01-ний дотор)-ээр нэгтгэн төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

6.4. Улсын байцаагч тодорхой нэр заасан гологдлын мэдээ, дүгнэлт ирүүлэхийг тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчоос шаардаж болно.

6.5. Сүйрэл, ослын жилийн мэдээ, баримтыг 45 жил, гологдлын жилийн мэдээ, баримтыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 5 жилийн хугацаагаар хадгална.

Долоо. Хариуцлага

7.1. Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----000-----

e-mail: jamaa_12@yahoo.com-aap санал авч байна. Та саналаа өгөхдөө нэр, хаяг, утас, майлээ тодорхой бичихийг хүсье.